

ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР



ГҮЙЦЭТГЭЛИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ОРОН НУТГИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТ ХӨГЖЛИЙН БОДЛОГО,
ТӨЛӨВЛӨЛТИЙН УРТ БОЛОН ДУНД ХУГАЦААНЫ БОДЛОГЫН БАРИМТ
БИЧГҮҮДТЭЙ НИЙЦСЭН ЭСЭХ, ЧАНАР, ҮР ДҮН, ҮР НӨЛӨӨ (2016-2021 ОН)

АУДИТЫН КОД: АГГ-2022/23-ШТА-ГА

ОРОН НУТГИЙН ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫГ УРТ ХУГАЦААНЫ
БОДЛОГЫН БАРИМТ БИЧГҮҮДИЙН ҮНДСЭН ЗОРИЛТУУДАЙ НИЙЦҮҮЛЭХ
ШААРДЛАГАТАЙ БАЙНА

Даланзадгад хот 2022 он



Дарга, Тэргүүлэх аудитор Ц.Өсөхбаяр

Утас: 70533539 Цахим хаяг: Usukhbayarts@audit.gov.mn

Аудитын менежер Т.Хонгорзул

Утас: 70533552 Цахим хаяг: Khongorzult@audit.gov.mn

Ахлах аудитор Г.Шижирболд

Утас: 70533552 Цахим хаяг: Shijirboldg@audit.gov.mn

Аудитор Ч.Наранбадрах

Утас: 70533552 Цахим хаяг: Naranbadrakhch@audit.gov.mn

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг дараах хаягаар
авна уу: Цахим хаяг: www.audit.mn

Аудитыг гүйцэтгэсэн:		Агуулга	Хуудас
Төрийн аудитын газрын дарга, Тэргүүлэх аудитор: Ц.Өсөхбаяр Аудитын менежер: Т.Хонгорзул Ахлах аудитор: Г.Шижирболд Аудитор: Ч.Наранбадрах 2022 оны 10 дугаар сар Аудитын тайлан, дүгнэлттэй холбоотой асуудлаар нэмж тодруулах, асууж лавлах зүйл байвал 70533539, 70533552 дугаарын утсаар харилцана уу. Тайланг ӨМТАГ-ын www.umnugovi@audit.gov.mn цахим хуудаснаас үзнэ үү. Хаяг: Нутгийн удирдлагын ордон, 3 давхар, 303 тоот		Товчилсон үгийн тайлбар	2
		Хүснэгт, график, зургийн жагсаалт	2
		Аудитын зорилт, арга зүй, стандартын талаарх мэдэгдэл	3-4
		Ерөнхий мэдээлэл	5
		Бүлэг 1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлоготой уялдсан байна.	6-11
		1.1 Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 90 хувь нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байна.	6-7
		1.2 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.	7-8
		1.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хөгжлийн индексийг харгалзаж үзэхгүй байна.	8-11
		Бүлэг 2. Хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна.	12-16
		2.1 Хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг, хэрэгжүүлсээр байна.	12-14
		2.2 Төсөл арга хэмжээний үр дүнг тооцохгүй байна.	14-16
		2.3 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлдэггүй байна.	16
		Дүгнэлт	17
		Зөвлөмж	18
		Тайлан баталгаажуулсан тушаал	19
		Хавсралтууд	

Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө (2016-2021 он)

ТОВЧИЛСОН ҮГИЙН ТАЙЛБАР

АДБОУБ	Аудитын дээд байгууллагын олон улсын байгууллага
АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
УИХ	Улсын Их Хурал
ИТХ	Иргэдийн төлөөлөгчдийн хурал
АЗДТГ	Аймгийн засаг даргын тамгын газар
ХШҮДАХ	Хяналт шинжилгээ үнэлгээ дотоод аудитын хэлтэс
ТАХ	Төсөл арга хэмжээ
ГХБХБГ	Газрын харилцаа барилга хот байгуулалтын газар

Хүснэгт, Дүрслэл, графикийн жагсаалт

Дугаар	Тайлбар	Хуудас
Хүснэгт 1	Төсөл арга хэмжээний ангилал	6
Хүснэгт 2	Хөрөнгө оруулалтыг дэвшүүлсэн зорилтоор ангилсан байдал	7
Хүснэгт 3	Алсын хараа 2050 урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй хөрөнгө оруулалтын жагсаалт	8
Хүснэгт 4	Төсөл арга хэмжээний задаргаа	8-9
Хүснэгт 5	Сумдын хөгжлийн индекс	9
Хүснэгт 6	Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016-2021 онуудад санхүүжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалт	12
Хүснэгт 7	Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ-ын жагсаалт	12-13
Хүснэгт 8	Оюутны хотхоны барилгын ажлын санхүүжилтийг төлөвлөсөн болон гүйцэтгэлээр олгосон байдал:	15
Хүснэгт 9	Аудитын зөрчлийн нэгтгэл	16
График 1	Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр	10
График 2	2016-2021 онд хийгдсэн ТАХ-г төрлөөр нь ангилбал	11
График 3	Улсын төсвийн байгууллагад хийсэн хөрөнгө оруулалтууд	13

Аудитын зорилт, арга зүйн талаарх мэдэгдэл	
Аудит хийх үндэслэл:	Аудитыг УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2021 оны 6 дугаар тогтоол, МҮЕА-ын 2022 оны А/12 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагын 2022 онд гүйцэтгэх аудитын төлөвлөгөө”-ний дагуу Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1-д заасан Төрийн аудитын газрын бүрэн эрхийн хүрээнд гүйцэтгэв.
Аудитын зорилт:	Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөөг үнэлж дүгнэн, аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн зөвлөмж боловсруулж, холбогдох байгууллага, албан тушаалтанд танилцуулахад аудитын зорилт чиглэгдэв. Аудитын зорилгыг хангахын тулд дараах дэд зорилтын хүрээнд аудитыг гүйцэтгэв. 1. Хөгжлийн бодлого, төлөвлөлтийг урт болон дунд хугацааны бодлоготой уялдсан эсэх 2. Хөрөнгө оруулалтын төсөл арга хэмжээ нь үр дүн, үр нөлөөтэй хэрэгжсэн эсэх
Аудитын арга зүй:	Аудитыг гүйцэтгэлийн аудитын стандарт АДБОУБ 3000-3100, Гүйцэтгэлийн аудитын үндсэн ойлголтын удирдамж УДИР 3910, УДИР 3920, Монгол Улсын Төрийн аудитын стандарт, MNS 6817-5:2020 “Гүйцэтгэлийн аудитын зарчим”, MNS 6817-7:2020 “Гүйцэтгэлийн аудитын стандарт”, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2021 оны А/69 дугаар тушаалаар баталсан “Гүйцэтгэлийн аудитын заавар, аргачлал”-д заасан арга зүйг ашиглан холбогдох албан тушаалтнуудтай ярилцлага хийх, асуулга лавлагаа, тодруулга болон судалгаа авах, харьцуулах, нэгтгэх, дүн шинжилгээ хийх зэрэг аудитын арга зүйг ашиглан, аудитын горимыг хэрэгжүүлж ажиллав.
Хамрах хүрээ:	Аудитаар аймаг, орон нутгийн ИТХ, аймгийн Засаг даргын Тамгын газар, тэдгээрийн харьяа байгууллага, төсөл арга хэмжээг гүйцэтгэгч зарим аж ахуй нэгж байгууллагын 2016-2021 оны үйл ажиллагааг хамруулав. Аудитыг нэгдсэн удирдамжаар гүйцэтгэв.
Аудитад ашигласан шалгуур:	Аудитад дараах хууль, эрх зүйн актыг шалгуур үзүүлэлт болгон ашиглалаа. <u>Хууль</u> ■ Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн тухай хууль /2015 он/ ■ Хөгжлийн бодлого, төлөвлөлт, түүний удирдлагын тухай хууль /2020 он/ ■ Монгол Улсын Засгийн газрын тухай хууль /1993/ ■ Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль; /2006, 2021 он/ ■ Төсвийн тогтвортой байдлын тухай хууль /2010 он/ ■ Монгол Улсын нэгдсэн төсвийн дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэл төсвийн төсөөллийн тухай хууль 2017, 2018, 2019, 2020 оны хууль ■ Монгол Улсын төсвийн тухай 2016 он, 2017 он, 2018 он, 2019 он, 2020 он, 2021 оны хууль /түүнд оруулсан нэмэлт өөрчлөлт/

Хүндрэл,
бэрхшээл:

Эрсдэлтэй
асуудал:

- Бүсчилсэн хөгжлийн удирдлага, зохицуулалтын тухай хууль /2003/
- Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хууль /2005/
- Авлигын эсрэг хууль /2006/
- Нийтийн албанд нийтийн болон хувийн ашиг сонирхлыг зохицуулах, ашиг сонирхлын зөрчлөөс урьдчилан сэргийлэх тухай хууль /2012/
- Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль /2015/
- Барилгын тухай хууль /2016/

Улсын Их Хурлын тогтоол

- УИХ-ын 2016 оны 19 дүгээр тогтоол “Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”
- УИХ-ын 2020 оны 52 дугаар тогтоолоор баталсан “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогын баримт бичиг
- УИХ-ын 2016 оны 45 дугаар тогтоол “Монгол Улсын Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 24 дүгээр тогтоолоор баталсан “Монгол Улсын Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөр”
- УИХ-ын 2020 оны 23 дугаар тогтоолоор баталсан “Монгол Улсын 2021-2025 оны хөрөнгө оруулалтын хөтөлбөр”
- УИХ-аас гаргасан холбогдох бусад тогтоол
- Засгийн газрын 2016 оны 121 дүгээр тогтоол “Монгол Улсын засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөө
- Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”
- Засгийн газраас гаргасан холбогдох бусад тогтоол, шийдвэрүүд

Салбарын эрх зүйн баримтууд

- Сангийн сайдын 2012 оны 290 дүгээр тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын журам”
- Сангийн сайдын 2016 оны 415 дугаар тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”

Аймаг, орон нутгийн ИТХ-ын тогтоол

- Өмнөговь аймгийн ИТХ-ын 2015 оны 9/7, 2016 оны 2/7, 3/10, 2017 оны 4/2, 5/3, 5/4, 2018 оны 5/4, 2019 оны 7/5, 8/1, 2020 оны 9/6, 2/7, 2021 оны 2/8, 3/2 тогтоолууд

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын 2020 оны аудитыг зөвхөн Даланзадгад сумын хэмжээнд хийсэн нь зарим тоо баримтад дүн шинжилгээ хийхэд хүндрэлтэй байсан.

Аудитын явцад 2016-2021 онуудад хэрэгжүүлсэн “Төрийн албан хаагчийн нийгмийн асуудлыг шийдвэрлэх, тусламж дэмжлэг үзүүлэх” хөтөлбөрийн хүрээнд 1 албан хаагчид жил дараалан 5-10 сая төгрөгийн тэтгэмж олгосон, Орон нутагтаа тогтвортой, амжилттай ажиллаж байгаа иргэнийг гадаад оронд мэргэшүүлэх, сургах “Зөгийн үүр” хөтөлбөрт хамруулсан нотлох баримт байхгүй, үр дүнг тооцоогүй зэрэг эрсдэлтэй асуудал гарсныг дараагийн аудитаар үзэх шаардлагатай байна.

ЕРӨНХИЙ МЭДЭЭЛЭЛ

УИХ-аас 2015 онд Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийг баталснаар Монгол Улсын хөгжлийн бодлого төлөвлөлтийн нэгдсэн тогтолцоог бүрдүүлэх эрх зүйн орчин бий болсон байна.

Хөгжлийн бодлого төлөвлөлтийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4-т “Дунд хугацааны буюу 3-5 жилийн хугацаанд хэрэгжүүлэх хөгжлийн бодлогын дараах баримт бичиг байна”, 6.4.4-т “улсын хөрөнгө оруулалтын хөтөлбөр” гэж заасан бөгөөд улсын төсвийг хөгжлийн бодлогын баримт бичгийг хэрэгжүүлэх санхүүжилтийн нэг эх үүсвэр байхаар хуульчилсан байна.

Аймгийн Иргэдийн төлөөлөгчдийн хурлын тогтоолуудаар 2016 онд 43 төсөл арга хэмжээнд 15,739.1 сая төгрөг, 2017 онд 121 төсөл арга хэмжээнд 35,796.1 сая төгрөг, 2018 онд 137 төсөл арга хэмжээнд 64,981.9 сая төгрөг, 2019 онд 85 төсөл арга хэмжээнд 63,331.1 сая төгрөг, 2020 онд 107 төсөл арга хэмжээнд 63,008.2 сая төгрөг, 2021 онд 90 төсөл арга хэмжээнд 50,085.4 сая төгрөгийн санхүүжилт олгохоор тус тус баталжээ.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016-2021 онуудад 1280 суудалтай 4 сургууль, 400 ортой 4 цэцэрлэг, 30 ортой 2 эмнэлэг, 47.2 км автозам, 250 суудалтай 1 соёлын төв, дэд бүтцийн 60 барилга, байгууламж ашиглалтад орсон байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлэн комисс хүлээн авч, байнгын ашиглалтад оруулсан төсөл, арга хэмжээний үр дүнг салбараар гаргаж харьцуулахад байгаль орчны салбараас бусад салбарт хийсэн хөрөнгө оруулалт өссөн үзүүлэлттэй байна.

Өмнөговь аймаг ашигт малтмалын 80 гаруй орд, 200 гаруй илрэлтэйгээс Таван толгой, Оюу толгой, Нарийн сухайт стратегийн ач холбогдолтой 3 томоохон орд газар тогтоогдож нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд Оюутолгой, Таван толгой, Эрдэнэс таван толгой, Энержи ресурс, Мөнх ноён суварга, Дун юань, Олон овоот гоулд, Зөв зүг, МАК, Чинхуа-Мак-Нарийн сухайт, Саус гоби сэндс, Өсөх зоос, Терра энерги, Жавхлант орд зэрэг компаниуд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

Уул уурхайн бүс нутгийн хувьд байгаль орчны тогтвортой хөгжлийн чиглэлээр хөрөнгө оруулалтыг төлөвлөж хэрэгжүүлээгүй байгаа нь экосистемийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж байна.

Жил бүр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24 -д заасантай нийцэхгүй орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авдаг зөрчил илэрсээр байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2021 онуудад 292,941.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 214,812.9 сая төгрөг зарцуулсан байна.

БҮЛЭГ 1 Хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлоготой уялдсан байна.

Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 90 хувь нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байна.

1.1.1 Монгол Улсын Их Хурлын 2016 оны 19 дүгээр тогтоолоор “Монгол Улсын Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” үзэл баримтлалыг 4 зорилттойгоор баталсан байна.

1.1.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2021 онуудад санхүүжүүлэхээр төлөвлөсөн 583 төсөл арга хэмжээ “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030” -ийн 4 зорилтын хүрээнд дараах байдлаар хуваагдаж байна.

Хүснэгт 1 Төсөл арга хэмжээний ангилал

Зорилт Он	Эдийн засгийн тогтвортой хөгжил	Нийгмийн тогтвортой хөгжил	Байгаль орчны тогтвортой хөгжил	Тогтвортой хөгжлийн засаглал
2016 он	18	10	1	4
2017 он	67	25	2	15
2018 он	71	39	3	10
2019 он	46	22	4	6
2020 он	58	45	2	2
2021 он	42	20	2	10
Нийт	302	161	14	47

Эх сурвалж: Гүйцэтгэлийн аудитын судалгаа-1

1.1.3 Дээрх судалгаанаас харахад 302 төсөл, арга хэмжээ буюу 51.8 хувийг эдийн засгийн тогтвортой хөгжил зорилтыг хангах чиглэлд төлөвлөсөн байна.

1.1.4 Энэ нь эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангахын тулд макро эдийн засгийн зохистой бодлогыг хэрэгжүүлж, эдийн засгийн бүтцийг төрөлжүүлнэ. хөдөө аж ахуй, аж үйлдвэр, түүний дотор хөнгөн, хүнс, барилгын материал, зэс боловсруулах, нүүрс, нефть хими, хар төмөрлөгийн үйлдвэрлэл, аялал жуулчлал, уул уурхайн олборлох салбарын хөгжилд тэргүүлэх ач холбогдол өгч, эрчим хүч, дэд бүтцийн салбарыг түрүүлж хөгжүүлэхэд чиглэгддэг байна.

1.1.5 Хэдий эдийн засгийн тогтвортой хөгжлийн зорилтыг хангах чиглэлд хөрөнгө оруулалт их хийсэн харагдаж байгаа ч томоохон бүтээн байгуулалт байхгүй, хэт жижиглэсэн зардлын шинж чанартай байна.

1.1.6 Байгаль орчны тогтвортой хөгжил зорилтыг хангах чиглэлд хамгийн бага буюу 14 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.1.7 Үзэл баримтлалд байгаль орчны тогтвортой хөгжил нь байгалийн нөөцийг үр өгөөжтэй ашиглан, экосистемийн тэнцвэрт байдлыг хадгалж, үр шимийг урт хугацаанд хүртэх боломжийг бүрдүүлэн хүртээмжтэй эдийн засгийн өсөлт, нийгмийн тогтвортой хөгжлийн суурь, хүний амьдралын чанарыг сайжруулах үндэс болно хэмээн заасан байна.

1.1.8 Өмнөговь аймаг ашигт малтмалын 80 гаруй орд, 200 гаруй илрэлтэйгээс Таван толгой, Оюу толгой, Нарийн сухайт стратегийн ач холбогдолтой 3 томоохон орд газар тогтоогдож

Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө (2016-2021 он)

нийт нутаг дэвсгэрийн хэмжээнд Оюутолгой, Таван толгой, Эрдэнэс таван толгой, Энержи ресурс, Мөнх ноён суварга, Дун юань, Олон овоот гоулд, Зөв зүг, МАК, Чинхуа-Мак-Нарийн сухайт, Саус гоби сэндс, Өсөх зоос, Терра энерги, Жавхлант орд зэрэг компаниуд ашигт малтмалын олборлолтын үйл ажиллагаа явуулж байна.

1.1.9 Уул уурхайн бүс нутгийн хувьд байгаль орчны тогтвортой хөгжлийн чиглэлээр хөрөнгө оруулалтыг төлөвлөж хэрэгжүүлээгүй байгаа нь экосистемийн тэнцвэрт байдалд сөргөөр нөлөөлж байна.

1.1.10 Байгаль орчин, аялал жуулчлалын яамнаас хийсэн судалгаагаар 2020 оны байдлаар уул уурхайн улмаас Өмнөговь аймгийн нийт газар нутгийн 50-70% цөлжилт, газрын доройтолд өртсөн гэсэн дүн гарсан байгаа нь дээрх чиглэлд анхаарах шаардлагатай байгааг харуулж байна.

1.1.11 Мөн “Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030”-ийн 4 зорилтод хамаарахгүй 59 төсөл арга хэмжээг төлөвлөсөн нь нийт төсөл арга хэмжээний 10 хувийг эзэлж байна.

1.1.12 Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.5¹ дахь заалттай нийцэхгүй байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.

1.2.1 Монгол Улсын Их Хурлын 2020 оны 5 дугаар сарын 13-ны өдрийн 52 дугаар тогтоолоор “Алсын хараа-2050” урт хугацааны хөгжлийн бодлогыг баталсан байна.

1.2.2 Энэ нь чанартай амьдралын баталгаа бүхий нийгмийн хамгаалалтай, аз жаргалтай амьдралын ээлтэй орчинд, гэр бүлийн амьдралын баталгаа, улс орны хөгжлийн суурь болсон чанартай боловсролыг хүн бүр эзэмших боломжийг бүрдүүлэн нийгмийн идэвхтэй, эрүүл монгол хүнийг хөгжүүлэхэд чиглэгддэг байна.

1.2.3 “Алсын хараа 2050” урт хугацааны бодлогын баримт бичигтэй уялдуулан төлөвлөсөн 197 төсөл арга хэмжээ зорилтоор нь ангилбал дараах байдалтай байна.

Хүснэгт 2 Хөрөнгө оруулалтыг дэвшүүлсэн зорилтоор ангилсан байдал

№	Зорилт	ТАХ-ны тоо	Эзлэх хувь
1	Хүний хөгжил	99	51.3
2	Амьдралын чанар ба дундаж давхарга	4	2
3	Амар тайван аюулгүй нийгэм	19	9.9
4	Эдийн засаг	2	0.6
5	Ногоон хөгжил	12	6.2
6	Бүсчилсэн хөгжил	1	1
7	Үндэсний нэгдмэл үнэт зүйл	10	5.1
8	Сайн засаглал	46	23.9
Нийт		193	100

Эх сурвалж: Гүйцэтгэлийн аудитын судалгаа №1

¹ тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх.

Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө (2016-2021 он)

1.2.4 Хүснэгтээс харахад “Хүний хөгжил”-ийн бүлэгт буюу Боловсрол, эрүүл мэнд, гэр бүл, хүнд ээлтэй орчинд чиглэсэн төсөл, арга хэмжээ их байгаа бол “Эдийн засаг”-т чиглэсэн төсөл, арга хэмжээ бага байна.

1.2.5 “Хүний хөгжил”, “Амьдралын чанар ба дундаж давхарга”, “Амар тайван аюулгүй нийгэм”-ийн бүлэгт хамаарах төсөл, арга хэмжээг хамгийн их хэрэгжүүлсэн бөгөөд Өмнөговь аймаг нь иргэдийнхээ боловсролыг дээшлүүлэх, эрүүл мэндийн үйлчилгээг сайжруулах, гэр бүл, өрхийн орлого нэмэгдүүлэх боломжийг бүрдүүлж, амар тайван амьдрах нөхцөлийг бүрдүүлэхээр бодлогын хүрээнд анхаарч ажилласан байна.

1.2.6 Харин “Эдийн засаг”, “Ногоон хөгжил”, “Бүсчилсэн хөгжил”-д чиглэсэн хөрөнгө оруулалт нь нийт төсөл, арга хэмжээний 8 хувийг эзэлж байгаа нь цаашид энэ талын төсөл, арга хэмжээг нэмэгдүүлэх шаардлага байгааг харуулж байна.

1.2.7 “Алсын хараа 2050” -ийн зорилттой уялдуулаагүй 4 төсөл арга хэмжээ байна.

1.2.8 Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 2.5² дахь заалттай нийцэхгүй байна.

Хүснэгт 3 Алсын хараа 2050 урт болон дунд хугацааны бодлогын баримт бичигтэй уялдаагүй хөрөнгө оруулалтын жагсаалт

№	Төсөл, арга хэмжээний нэр	Төсөв
1	Орон нутгийн болон хот доторх нийтийн тээврийн үйлчилгээний хэвийн үйл ажиллагааг хангах хүрээнд 8 эко бусын зайг шинэчлэх	50.0
2	"Дорж Мээрэн хэмээх Бунибазарын Дорж агсан"-ы цээж баримал цогцолбор бүтээх	32.4
3	Даланзадгад ахуйн үйлчилгээний барилгын дээврийн засварын ажил	52.6
4	Аймгийн ахмадын хорооны дотор дулааны шугам сүлжээний засвар, шинэчлэл	23.3
Нийт		158.3

Эх сурвалж: Хавсралт судалгаа №1

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хөгжлийн индексийг харгалзаж үзэхгүй байна.

1.3.1 Улсын Их Хурлын 2016 оны 45 дугаар тогтоолоор Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр, УИХ-ын 24 дүгээр тогтоолоор Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус баталсан байна.

1.3.2 Аймгийн орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2021 онуудад хэрэгжүүлэхээр төлөвлөсөн төсөл, арга хэмжээ Засгийн газрын үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилтыг хангахад чиглэсэн байна.

Хүснэгт 4 Төсөл арга хэмжээний задаргаа

№	Засгийн газрын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт	Төсөл, арга хэмжээний тоо	Засгийн газрын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийн зорилт	Төсөл, арга хэмжээний тоо
1	Эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлого	137	Хүний хөгжлийн бодлого	63
2	Нийгмийн бодлого	129	Эдийн засгийн бодлого	84

² тухайн жилийн төсвийн хязгаарт багтсан, хөгжлийн бодлогын зорилтуудтай уялдсан байх.

Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө (2016-2021 он)

3	Байгаль орчин, ногоон хөгжлийн бодлого	15	Засаглалын бодлого	33
4	Засаглалын бодлого	105	Ногоон хөгжлийн бодлого	1
5			Нийслэл ба бүс, орон нутгийн хөгжлийн бодлого	16
	Дүн	386		197

Эх сурвалж: Хавсралт судалгаа №1

1.3.3 Хүснэгтээс харахад эдийн засгийн тогтвортой өсөлтийг хангах бодлогын чиглэлээр 35.5 хувь, нийгмийн бодлогын чиглэлээр 33.4 хувь, засаглалын бодлогын чиглэлээр 27.2 хувь, байгаль орчин, ногоон хөгжлийн бодлогын чиглэлээр 3.9 хувийг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

1.3.4 Харин 2020-2021 оны төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт хүний хөгжлийн бодлогын чиглэлээр 31.9 хувь, эдийн засгийн бодлогын чиглэлээр 42.6 хувь, засаглалын бодлогын чиглэлээр 16.7 хувь, ногоон хөгжлийн бодлогын чиглэлээр 0.1 хувь, нийслэл ба бүс орон нутгийн хөгжлийн бодлогын чиглэлээр 8.7 хувь чиглэсэн байна.

1.3.5 Үндэсний хөгжлийн газраас "Орон нутгийн хөгжлийн индекс тооцох аргачлал"-ын дагуу боловсрол, эрүүл мэнд, эдийн засаг, бусад, дэд бүтэц, байгаль орчин гэсэн 6 үзүүлэлтээр хөгжлийн индексийг тодорхойлжээ.

Хүснэгт 5 Сумдын хөгжлийн индекс

№	Сумдын нэр	Боловсрол	Эрүүл мэнд	Эдийн засаг	Бусад	Дэд бүтэц	Байгаль орчин
1	Баяндалай	0.79	0.76	0.31	0.94	0.69	1.0
2	Баян-Овоо	0.78	0.90	0.41	0.92	0.44	1.0
3	Булган	0.72	0.66	0.30	0.54	0.43	1.0
4	Гурвантэс	0.76	0.68	0.51	0.43	0.66	1.0
5	Даланзадгад	0.67	0.81	0.50	0.89	0.65	0.83
6	Мандал-Овоо	0.83	0.70	0.31	0.64	0.45	1.0
7	Манлай	0.71	0.65	0.37	0.64	0.50	1.0
8	Ноён	0.83	0.72	0.43	0.95	0.48	1.0
9	Номгон	0.69	0.64	0.35	0.93	0.49	1.0
10	Сэврэй	0.85	0.72	0.34	0.98	0.51	1.0
11	Ханбогд	0.59	0.89	0.65	0.67	0.41	1.0
12	Ханхонгор	0.79	0.76	0.35	0.90	0.41	0.83
13	Хүрмэн	0.58	0.82	0.44	0.86	0.57	1.0
14	Цогт-Овоо	0.87	0.76	0.35	0.60	0.72	1.0
15	Цогтцэций	0.67	0.91	0.68	0.85	0.48	1.0
16	Аймгийн дундаж	0.74	0.76	0.42	0.78	0.53	0.98

Эх сурвалж: Эдийн засаг хөгжлийн яам

1.3.6 Судалгаагаар аймгийн дундаж дүнгээр эдийн засаг, дэд бүтэц хамгийн бага түвшинд байгаа бол байгаль орчны үзүүлэлтүүд хамгийн өндөр байна.

1.3.7 Эдийн засгийн чиглэлээр тайлант хугацаанд хамгийн бага хөрөнгө оруулалт хийсэн нь хөгжлийн индекс бага түвшинд байхад нөлөөлсөн байна.

1.3.8 Энэ нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтийг хөгжлийн индекстэй нийцүүлэн төлөвлөхгүй байгаатай холбоотой байна.

1.3.9 Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2016 оны 2/2 дугаар тогтоолоор Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөр, 2020 оны 2/4

Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө (2016-2021 он)

дугаар тогтоолоор аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны хөтөлбөрийг тус тус баталсан байна.

1.3.10 Аймгийн Засаг даргын 2016-2020 оны үйл ажиллагааны хөтөлбөр нь 4 бүлэг, 16 зорилт, 386 заалттай бөгөөд үүнээс нийгмийн хөгжлийн бодлогын хүрээнд 112, эдийн засаг, хөрөнгө оруулалтын бодлогын хүрээнд 154, байгаль орчныг хамгаалах бодлогын хүрээнд 14, орон нутгийн засаглалын бодлогын хүрээнд 106 заалттай хамааралтай байна.

1.3.11 Харин аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны 6 бүлэг, 28 зорилт, 211 арга хэмжээг багтаасан байна.


1.3.12 Үүнд Итгэл-эрүүл мэнд, нийгмийн хамгааллын бодлого 17, Ирээдүй-Боловсрол, инновацын хөгжлийн бодлого 68, Хөгжил- эдийн засаг, нутгийн үйлдвэрлэлийн бодлого 13, Шударга-хүний эрх, эрх чөлөө, засаглалын бодлого 83, Байгаль орчин, хариуцлагатай уул уурхай, ус, бэлчээрийг хамгаалах бодлогын хүрээнд 12 заалттай нийцүүлж төлөвлөсөн байна.

1.3.13 Эдийн засаг хөрөнгө оруулалтын бодлогод чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний тоо 154 буюу нийт заалтын 40 хувь, нийгмийн хөгжлийн бодлогод чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний тоо 112 буюу 29 хувь, байгаль орчныг хамгаалах бодлогод чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний тоо 14 буюу 4 хувь, орон нутгийн засаглалын бодлогод чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээний тоо 106 буюу 27 хувь тус тус эзэлж байна.

1.3.14 Үүнээс харахад Эдийн засаг хөрөнгө оруулалтын бодлогод чиглэсэн төсөл, арга хэмжээ хамгийн их буюу 40 хувь, байгаль орчныг хамгаалах бодлогод чиглэсэн хөрөнгө оруулалт, төсөл арга хэмжээ хамгийн бага буюу 4 хувь байна.

1.3.15 АЗДТГ-ын ХШҮДАХ-ээс Өмнөговь аймгийг 2016-2020 онд хөгжүүлэх аймгийн Засаг даргын үйл ажиллагааны хөтөлбөрийн хэрэгжилтэд хяналт-шинжилгээ, үнэлгээ хийж хөтөлбөрийг 88.6 хувийн биелэлттэй гэж дүгнэжээ.

График 1 Аймгийн Засаг даргын 2020-2024 онд хэрэгжүүлэх үйл ажиллагааны хөтөлбөр



Эх сурвалж: Хавсралт судалгаа 1

Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө (2016-2021 он)

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ач холбогдол, хэрэгцээ шаардлага тодорхойлогдоггүй байна.

1.4.1 Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ач холбогдол, хэрэгцээ шаардлага, хүрэх үр дүнг Сангийн сайдын 2016 оны 415 тоот тушаалаар баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтын төлөвлөлт, санхүүжилт, хяналт, тайлагналын журам”, Засгийн газрын 2021 оны 160 дугаар тогтоол “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-д заасны дагуу тэдгээрт нийцүүлэн тодорхойлдог байна.

1.4.2 Орон нутгийн болон улсын төсвийн байгууллагуудаас тухайн байгууллагадаа тулгамдсан асуудлаар АЗДТГ-т тухайн жилийн орон нутгийн төсвийн хөрөнгөөр хийлгэх ажлын хүсэлтийг хүргүүлдэг байна.


1.4.3 Хүсэлтүүдийг эрэмбэлж орон нутгийн төсвийн төсөлд тусган ИТХ-д оруулан орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хийх төсөл, арга хэмжээг аймгийн төлөөлөгч нар хэлэлцэн баталдаг байна.

1.4.4 Өмнөговь аймгийн ИТХ 33 мандаттайгаас Даланзадгад сум 12, Цогтцэций сум 4, Ханбогд сум 3 төлөөлөгчтэй бусад сум тус бүр 1 төлөөлөгчтэй байгаа нь орон нутгийн хөрөнгө оруулалт сумдын хэмжээнд ялгаатай батлагдах эрсдэлтэй байна.

1.4.5 Иргэдийн Төлөөлөгчдийн хурлын 2016-2021 оны тогтоолуудаар орон нутгийн төсвийн хөрөнгөөр 583 төсөл, арга хэмжээг баталсан боловч гэрээ байгуулж хэрэгжүүлэхдээ төсөл, арга хэмжээ болгосон байна.

1.4.6 Энэ нь Төсвийн тухай хуулийн 41 дүгээр зүйлийн 41.2.2 “Батлагдсан төсвийн хүрээнд зарлага гаргах”-дахь заалттай нийцэхгүй байна.

График 2 2016-2021 онд хийгдсэн ТАХ-г төрлөөр нь ангилбал



Эх сурвалж: Хавсралт судалгаа 7

1.4.7 ТАХ-г төрлөөр нь авч үзвэл 211 ТАХ буюу 36 % нь барилга, байгууламж барих, засварын ажил байна.

1.4.8 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2021 оны төсөл, арга хэмжээнд дүн шинжилгээ хийж үзвэл дийлэнх нь барилгын засвар тохижилтын ажлууд байх бөгөөд иргэд, ААНБ-аас ирж буй саналыг оновчтой эрэмбэлээгүйгээс хэрэгцээ шаардлагыг зөв тодорхойлж чадахгүй байгааг харуулж байна.

БҮЛЭГ 2 Хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлсэн нь хөрөнгө оруулалтын үр дүнг бууруулж байна

Хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг, хэрэгжүүлсээр байна.

2.1.1 Өмнөговь аймгийн хэмжээнд 2016-2021 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгөөр хэрэгжүүлэхээр нийт 583 төсөл арга хэмжээнд 292,941.8 сая төгрөгөөр санхүүжүүлэхээр АИТХ-ын тогтоолоор баталсан байна.

Хүснэгт 6 Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2016-2021 онуудад санхүүжүүлэхээр баталсан хөрөнгө оруулалт (сая төгрөг)

Д/д	Огноо	Шийдвэрийн дугаар	Төсөл арга хэмжээний тоо	Санхүүжүүлэхээр баталсан мөнгөн дүн
1	2016	Аймгийн ИТХ-ын 2015 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 9/7 дугаар тогтоол, 2016 оны 09 дүгээр сарын 29-ны өдрийн 2/1 дугаар тодотгол	43	15,739.1
2	2017	Аймгийн ИТХ-ын 2016 оны 12 дугаар сарын 02-ны өдрийн 3/10 дугаар тогтоол, 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 5/3 дугаар тодотгол	121	35,796.1
3	2018	Аймгийн ИТХ-ын 2017 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 5/4 дугаар тогтоол	137	64,981.9
4	2019	Аймгийн ИТХ-ын 2018 оны 11 дугаар сарын 29-ны өдрийн 7/5 дугаар тогтоол, 2019 оны 4 дүгээр сарын 25-ны өдрийн 8/1 дугаар тодотгол	85	63,331.1
5	2020	Аймгийн ИТХ-ын 2019 оны 12 дугаар сарын 04-ны өдрийн 9/6 дугаар тогтоол, 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 2/7 дугаар тодотгол	107	63,008.3
6	2021	Аймгийн ИТХ-ын 2020 оны 12 дугаар сарын 03-ны өдрийн 2/8 дугаар тогтоол, 2021 оны 8 дугаар сарын 25-ны өдрийн 3/2 дугаар тодотгол	90	50,085.4
Нийт дүн			583	292,941.8

Эх сурвалж: Гүйцэтгэлийн аудитын тайлан, АИТХ-ын тогтоолууд

2.1.2 Жил бүр орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтад хийсэн гүйцэтгэлийн аудитаар Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.24³-д заасантай нийцэхгүй орон нутгийн өмчлөлд хамаарахгүй, улсын төсвийн байгууллагуудын урсгал болон хөрөнгө худалдан авахад нийт 92,236.3 сая төгрөг баталсан зөрчил илэрсэн.

Хүснэгт 7 Хөрөнгө оруулалтын бус шинж чанартай ТАХ-ын жагсаалт (сая. төгрөг)

Д/д	ТАХ-ний нэр	Огноо	Төсөвт өртөг
1	Хүмүүнлэгийн хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2016	4.7
2	Спортын амжилтыг дэмжин хөгжүүлж, нийтийн биеийн тамирыг бүх нийтийн үйлс болгох арга хэмжээ зохион байгуулах	2016	15.5
3	Засаг даргын нэрэмжит оюутны орон нутгийн тэтгэлэгт хөтөлбөрийг үргэлжлүүлэн хэрэгжүүлэх	2016	190.9
4	Орон нутгийн соёлын өвийг хамгаалах, судлах, дэлгэрүүлэх, уламжлалт уралдаан тэмцээн, наадам зохион байгуулах, онгон дагшин байгалиа хамгаалах үндэсний хэмжээнд таниулах олон нийтэд түгээн дэлгэрүүлэх	2016	33.4
5	Орон нутгийн соёлын өвийг сэргээн Цамын бүжгийг туурвих	2016	80.1
6	Мэргэжлийн урлагийн байгууллагын боловсон хүчнийг чадавхжуулан, номын сан, музейн сан хөмрөгийг баяжуулах	2016	36.6
7	"Залуучуудын хөгжил" хөтөлбөр боловсруулж, хэрэгжүүлэн, хөдөлмөр эрхлэлтийг нэмэгдүүлэх	2016	20.0
8	"Өрх гэр бүлийг дэмжих", "Ажилтай орлоготой эмэгтэйчүүд", "40-с дээш насны ажил олоход бэрхшээлтэй иргэнийг ажлын байраар хангах"	2016	299.9

³ "төсвийн хөрөнгө оруулалт" гэж улсын болон орон нутгийн төсвөөс санхүүжүүлж, тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжих хөрөнгийн зарлагыг

Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө (2016-2021 он)


	хөтөлбөрүүдийг үргэлжлүүлэн хэрэгжүүлж, шинэ ажлын байрыг бий болгон өрхийн амьжиргааг дээшлүүлэх		
9	"Монгол тэмээ-999" дэлхийн дээд амжилтад бүртгүүлэх тэмээний уралдааныг зохион байгуулах	2016	199.9
10	Төрийн албан хаагчийн ажиллах нөхцөл, нийгмийн баталгааг хангах талаар авах арга хэмжээ	2016	499.5
11	"Архигүй Өмнөговь" хөтөлбөрийг үр дүнтэй хэрэгжүүлэх	2016	6.8
12	Далангийн цөөрмийг лайдах	2016	83.2
	Нийт дүн		1,470.5
1	Нутгийн удирдлагын ордонд Уул уурхайн мэдээллийн булан байгуулах.	2017	9.9
2	Даланзадгад сумын Далан булгийн Далангийн цөөрмийг лайдах	2017	83.3
3	Аймгийн онцлогийг илэрхийлсэн бэлэг дурсгал бий болгох	2017	154.3
4	Орон нутгийн цэргийн алба хаагчдын нийгмийн асуудлыг шийдвэрлэх	2017	15.0
5	Сумдын газар зохион байгуулалтын болон хөгжлийн ерөнхий төлөвлөгөө боловсруулах ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлэх	2017	78.3
6	Аймгийн хэмжээний сургууль, цэцэрлэгийн ариутгал, халдваргүйжүүлэлтийг хийх	2017	18.6
	Нийт дүн		359.4
1	Сумын хөгжлийн ерөнхий төлөвлөгөөг шинэчлэн боловсруулах	2018	92.2
	Нийт дүн		92.2

Эх сурвалж: Гүйцэтгэлийн аудитын тайлан, АИТХ-ын тогтоолууд

2.1.3 Дээрх хүснэгтээс харахад жил бүр хийсэн гүйцэтгэлийн аудитаас өгсөн зөвлөмж, албан шаардлагын үр дүнд 2019 оноос хойш хөрөнгө оруулалтын бус шинжтэй төсөл арга хэмжээг санхүүжүүлсэн зөрчил давтан гараагүй байна.

2.1.4 Гэвч тухайн шатны төсөвт хамаарах хуулийн этгээдийн өмчлөлд шилжихгүй төсөл арга хэмжээг орон нутгийн төсвийн хөрөнгөөр санхүүжүүлсээр байгаа нь төсвийн зохистой удирдлагыг хэрэгжүүлэх зарчмыг алдагдуулж байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 4 харна уу)

График 3 Улсын төсвийн байгууллагад хийсэн хөрөнгө оруулалтууд (сая төгрөг)



2.1.5 Мөн Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4⁴ -т заасны дагуу техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвийг батлуулсан байх шаардлагыг хангаагүй нийт 10,941.6 сая төгрөгийн 19 төсөл арга хэмжээг баталсан байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 5 харна уу)

2.1.6 Төлөвлөлтийн шаардлага хангахгүй төсөл арга хэмжээг баталж байгаа нь төсвийн төлөвлөлтийн зарчим хангагдахгүй байгааг харуулж байна.

2.1.7 Орон нутагт гүйцэтгэх засаглал солигдох, төрийн байгууллагуудын уялдаа хангалтгүй, хариуцлага тооцох асуудал сул байгаа нь хөрөнгө оруулалтын төлөвлөлтийн тогтолцоо алдагдах нөхцөлийг бүрдүүлж байна.

4 Хөрөнгө оруулалтын төсөвт техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.

2.3.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжиж байгаа төсөл арга хэмжээнд захиалагчийн хяналтыг ГХБХБГ хэрэгжүүлж байна.

2.1.8 Үе шатны хяналтын явцад илэрсэн алдаа зөрчлийг тухай бүр арилгуулах арга хэмжээ авдаггүйгээс өгсөн үүрэг даалгавар бүрэн биелээгүй байхад улсын комиссын акт үйлдэж баталгаажуулдаг байна.

2.1.9 Энэ хөрөнгийн үр өгөөжийн бууруулж, үргүй зардал гарах эрсдэлийг нэмэгдүүлж байна.

Төсөл арга хэмжээний үр дүнг тооцохгүй байна.

2.2.1 Төсөл арга хэмжээний хэрэгжилтийн явц, үр дүнг нэгтгэсэн мэдээллийн сан байдаггүй байна.

2.2.2 Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар 2016-2021 онуудад 292,941.8 сая төгрөгийн санхүүжилт олгохоор төлөвлөснөөс гүйцэтгэлээр 214,812.9 сая төгрөг зарцуулсан байна. (Дэлгэрэнгүйг судалгаа 5 харна уу)

2.2.2 Хөрөнгө оруулалтаар хийсэн боловсролын байгууллагын сургуулийн барилгын хүчин чадлыг суралцаж буй хүүхдийн тоотой⁵ харьцуулан үзэхэд:

Төрийн өмчийн ерөнхий боловсролын сургууль:

- Цогт-Овоо суманд 320 хүүхдийн сургуулийн барилга - суралцаж байгаа хүүхдийн тооноос 120 хүүхдээр хэтэрсэн,
- Хүрмэн сумын 320 хүүхдийн сургуулийн барилга- суралцаж байгаа хүүхдийн тооноос 160 хүүхдээр хэтэрсэн,
- Сэврэй сумын 320 хүүхдийн сургуулийн барилга- суралцаж байгаа хүүхдийн тооноос 113 хүүхдээр хэтэрсэн,
- Номгон сумын 320 хүүхдийн сургуулийн барилга- суралцаж байгаа хүүхдийн тооноос 69 хүүхдээр хэтэрсэн,

2.2.3 Энэ нь ерөнхий боловсролын сургуулийн барилгын хэрэгцээ, шаардлагын бодитой төлөвлөдөггүйг харуулж байна.

2.2.4 Мөн хөрөнгө оруулалтаар тоног төхөөрөмжийг хэрхэн ашиглах талаар сургалт, зааварчилгаа өгөөгүйгээс ашиглаж чадахгүй, хэрэгцээ шаардлагад тулгуурлаж худалдан авалт хийгээгүйгээс илүүдэлтэй, хөрөнгийг бүртгэлд тусгаагүй, чанаргүй хөрөнгө нийлүүлсэн зэрэг зөрчил жил бүр нийтлэг илэрдэг нь хөрөнгө оруулалтын үр өгөөжийг бууруулж байна.

Хөрөнгө оруулалтыг данс бүртгэлд тусгаагүй:

- Хилийн цэргийн 0131-р ангид нийлүүлсэн 4 камер 5.1 сая төгрөг (2016 он)
- Цамын бүжгийг туурвих ажил 80.0 сая төгрөг (2016 он)
- Даланзадгад суманд байгуулсан хөл бөмбөгийн талбай 889.9 сая төгрөг (2017 он)
- Жуулчны гудамж байгуулах ажил 68.2 сая төгрөг, (2017 он)
- Ханбогд сумын төвийн дулааны шугам сүлжээний өргөтгөл 378.4 сая төгрөг (2017 он)

⁵Барилга байгууламжийн хүчин чадлыг суралцаж байгаа хүүхдийн тоотой харьцуулж зөрүүг гарган +30 хооронд байвал ойролцоо түвшинд түүнээс дээш гарсныг хэтэрснээр тооцсон болно.

Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө (2016-2021 он)

- Даланзадгад сумын 26 дугаар цэцэрлэгт нийлүүлсэн тоглоом 24.5 сая төгрөг (2017 он)
- Даланзадгад суманд байгуулсан өвлийн хүлэмж 360.0 сая төгрөг, (2017 он)
- БОЭТ-ийн 50 ортой эмнэлийг засварын зураг төсөв 19.8 сая төгрөг (2019 он)
- Инженерийн хийцтэй худаг 58.3 сая төгрөг (2019 он)
- Мандал-Овоо сумын нийтийн эзэмшлийн ногоон байгууламж бүхий талбай 211.2 сая төгрөг,

Чанарын шаардлага хангахгүй болон ашиглахгүй байгаа тоног төхөөрөмж:

- Даланзадгад сумын 25, 26 дугаар цэцэрлэгт нийлүүлсэн тоглоом ашиглах боломжгүй 49.1 сая төгрөг (2017 он)
- Цагдаагийн газарт 102.9 сая төгрөгийн өртөгтэй 3 автомашин нийлүүлсэн нь техникийн тодорхойлолтод зааснаас зөрүүтэй (2020 он)
- Цогтцэций сумын гадаа байрлах LED дэлгэц ашиглах боломжгүй 50.0 сая төгрөг (2020 он)
- Цогтцэций сумын эмнэлэгт нийлүүлсэн тоног төхөөрөмжийг ажиллуулах мэргэжлийн эмч байхгүй учраас ашиглах боломжгүй 35.8 сая төгрөг (2020 он)
- Гэр хорооллын хог ангилан ялгах тоног төхөөрөмжийг бүрэн ашиглаагүй (2021 он)
- Булган сумын сургууль нийлүүлсэн тоног төхөөрөмжийг ашиглаагүй
- Барилгын материалын лабораторийн 28.3 сая төгрөгийн тоног төхөөрөмж бүрэн нийлүүлэгдээгүй,

2.2.5 Дээрх зөрчлүүдээс харахад хөрөнгө оруулалт төсөл арга хэмжээний хүрэх үр дүн тооцдоггүй байна.

2.2.6 Мөн томоохон бүтээн байгуулалтын нэг болох Улаанбаатар хотод барьж байгуулах 500 оюутны хотхоны барилгын ажлын үнэлгээний хороог Аймгийн ЗДТГ-ын даргын тушаалаар 7 хүний бүрэлдэхүүнтэй томилж, уг ажлын хэсгийн дүгнэлтээр “Мэнд констракшн” ХХК-тай 9,609.8 сая төгрөгийн гэрээ байгуулсан байна.

2.2.7 Тус барилгын ажлыг 2021 онд эх үүсвэргүй гэх шалтгаанаар санхүүжилт олгоогүй байна.

2.2.8 Гэрээнд заасан дагуу тус ажлыг 2019 оны 10 дугаар сарын 01-ны өдрөөс эхэлж 2020 оны 12 дугаар сарын 01-ны өдөр хүртэл хугацаанд дуусгах гэрээ байгуулсан ч одоогийн байдлаар барилгын ажил дуусаагүй 6,225.9 сая төгрөгийн санхүүжилт олгогдсон байна.

Хүснэгт 8 Оюутны хотхоны барилгын ажлын санхүүжилтийг төлөвлөсөн болон гүйцэтгэлээр олгосон байдал: (сая төгрөг)

Гэрээний дүн	2019 он		2020 он		2022 он		Нийт	
	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Төлөвлөгөө	Гүйцэтгэл
9,609.8	490.0	490.0	3,490.0	3,460.0	2,345.0	2,275.9	6,325.0	6,225.9

Эх сурвалж: Төрийн сангийн дансны хууль

Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө (2016-2021 он)

2.2.9 Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2⁶-д заасны дагуу төсвийн төсөлд санал өгөхдөө хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардлын тооцоог гаргаж төсөвт тусгасан байна. Тухайлбал

- 850 хүний суудалтай хөгжимт жүжгийн театр
- Аймгийн шинэ музейн барилга
- Соёл спортын цогцолбор

2.1.10 Орон нутгийн хөрөнгө оруулалтын дүн сум тус бүрийн хүн амын тоотой харьцуулахад 1 хүнд ногдох дүнгээрээ Баяндалай сум 7.7 сая төгрөг байгаа бол Цогтцэций сум 0.7 сая төгрөг байна. (Дэлгэрэнгүйг хавсралт 4 харна уу)

2.2.10 Харьцуулсан судалгаагаар сумдын 1 хүнд ногдох хөрөнгө оруулалтын хоорондын зөрүү их байгаа нь хэнийг ч орхигдуулахгүй байх зарчим үйлчлэхгүй байгааг харуулж байна.

Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлдэггүй байна

2.3.2. Аймгийн төсвийн ерөнхийлөн захирагчийн дотоод хяналт болох Санхүүгийн хяналт, аудитын алба нь 2016-2021 онуудад орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын хэрэгжилт, гүйцэтгэлийн байдалд хяналт шалгалт хийж, үнэлэлт дүгнэлт өгөөгүй байна.

2.3.3. Энэ нь Төсвийн тухай хуулийн 69 дүгээр зүйлийн 69.1⁷ дахь заалттай нийцэхгүй байна.

2.2.2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын үр дүнд 2016-2021 онуудад хийсэн аудитаар 28,340.8 сая төгрөгийн зөрчил илрүүлж, 26,731.0 сая төгрөгийн албан шаардлага, 1,609.8 сая төгрөгийн зөвлөмж өгч, биелэлт 88 хувьтай байна.

2.2.3. Алдаа зөрчил жил бүр давтан гарч байгаа нь аудитаар өгсөн албан шаардлагыг бүрэн биелүүлэхгүй байгаатай холбоотой байна.

Хүснэгт 9 Аудитын зөрчлийн нэгтгэл

Он	Нийт зөрчлийн дүн	Үүнээс:		Биелэлт (хувиар)	
		Албан шаардлага	Зөвлөмж	Албан шаардлага	Зөвлөмж
2016	3,066.8	1,666.7	1,400.1	90	100
2017	7,125.0	7,125.0		85	
2018	2,556.9	2,556.9		90	
2019	129.8	129.8		90	
2021	15,462.3	15,252.6	209.7	Хэрэгжилт тооцох хугацаа болоогүй	
Нийт дүн	28,340.8	26,731.0	1,609.8		

Эх сурвалж: Аудитын тайлан, статистик мэдээ

⁶ Хөрөнгө оруулалтын төслийн саналд үндсэн хөрөнгийн ашиглалттай холбоотой урсгал зардал, орон тоо, санхүүжүүлэх эх үүсвэр зэрэг холбогдох тооцоог хавсаргаж, төсөвт нөлөөлөх ачааллын талаарх дүгнэлтийг гаргасан байна.

⁷ Төсвийн ерөнхийлөн захирагч бүр хууль тогтоомжийн хэрэгжилтэд хяналт тавих, төсвийн хөрөнгө, өр, төлбөр, орлого, зарлага, хөтөлбөр, арга хэмжээ, хөрөнгө оруулалтад санхүүгийн хяналт, шалгалт хийх, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргах, эрсдэлийн удирдлагаар хангахад чиглэсэн дотоод аудитын албыг байгуулж, дотоод аудитор ажиллуулна”

ДҮГНЭЛТ

Аудитын дүнд үндэслэн дараах дүгнэлтийг гаргаж байна.

- Хэрэгжүүлсэн төсөл арга хэмжээний 90 хувь нь Тогтвортой хөгжлийн үзэл баримтлал-2030 урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцэж байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээ нь Алсын хараа 2050 урт хугацааны бодлогын баримт бичигтэй нийцсэн байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө хөгжлийн индексийг харгалзаж үзэхгүй байна.
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний ач холбогдол, хэрэгцээ шаардлага тодорхойлдоггүй байна.
- Хуулийн шаардлага хангаагүй төсөл, арга хэмжээг, хэрэгжүүлсээр байна.
- Төсөл арга хэмжээний үр дүнг тооцохгүй байна
- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээнд дотоод хяналтыг хэрэгжүүлдэггүй байна

ЗӨВЛӨМЖ

Аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурал:

- Төсвийн хөрөнгө оруулалтаар хийх төсөл, арга хэмжээг ерөнхий нэрээр бус төсөл арга хэмжээ тус бүрээр батлах.

Аймгийн Засаг даргад:

- Хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө сумдын болон аймгийн хөгжлийн индексийг харгалзан уялдуулж байх,
- Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2.5 дахь заалтыг хэрэгжүүлж ажиллах,
- Төсвийн хөрөнгө оруулалтаар хийх төсөл, арга хэмжээг ерөнхий нэрээр бус төсөл арга хэмжээ тус бүрээр батлуулах,
- Хэрэгжүүлсэн төсөл, арга хэмжээнд дотоод хяналт хийж, үнэлэлт, дүгнэлт, зөвлөмж гаргаж байх.

ТАЙЛАН БАТАЛГААЖУУЛСАН ТУШААЛ



ӨМНӨГОВЬ АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН ТУШААЛ

2022 оны 10 сарын 10 өдөр

Дугаар А/23

Даланзадгад

“Аудитын тайлан баталгаажуулах тухай”

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйл, 9 дүгээр зүйлийн 9.1 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”-ийн 18.9 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. “Орон нутгийн хөрөнгө оруулалт хөгжлийн бодлого, төлөвлөлтийн урт болон дунд хугацааны бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн эсэх, чанар, үр дүн, үр нөлөө” -д хийсэн гүйцэтгэлийн аудитын тайланг баталгаажуулсугай.
2. Аудитын тайланг Гүйцэтгэл-Нийцлийн аудитын газар, аймгийн Засаг даргад тус тус хүргүүлсүгэй.
3. Аудиттай холбоотой ажлын нотлох баримтыг тайлан баталгаажуулснаас хойш 14 хоногийн дотор архивын нэгж болгон хүлээлгэн өгөх, аудитын тайланг хэвлэл мэдээллийн хэрэгслээр мэдээлэхийг аудитор (Ч.Наранбадрах)-д үүрэг болгосугай.



Ц.ӨСӨХБАЯР

D:\Бичиг Хэрэг\А Тушаал 2022\А-23.Docx

016010023